

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2016 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2016 оны 06 сарын 10

Улаанбаатар хот

НЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААР

Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 21 ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, 3 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, 11 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, 1 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх асуудлыг Хорооны хуралдаанаар шийдвэрлэж 2016 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 271 хадгаламж, зээлийн хоршоо /цаашид “ХЗХ” гэх/ Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.


Хадгаламж, зээлийн хоршоодыг үйл ажиллагааны төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ХЗХ-дын тоо	
		2015 онд	2016 оны I
1	Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй	253	271
	Үүнээс:		
2	Төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй	114	114
3	Санхүүгийн түрээсийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй	1	1
4	Салбарын зөвшөөрөлтэй	4	4


ХЗХ-дын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн зохицуулалттай холбоотой 902 асуудлыг Хорооны хуралдаанаар шийдвэрлэснийг он болон төрөл тус бүрээр харуулбал:

Онууд	Шинээр олгосон	Хүчингүй болгосон	Түдгэлзүүлсэн	Сэргээсэн	ГЗ-ийн хугацаа сунгасан	ХЗХ-дын тоо (оны эцэст)
2006 он	51	-	-	-	-	51
2007 он	128	-	-	-	-	179
2008 он	45	15	5	-	-	209
2009 он	15	12	8	1	25	212
2010 он	2	35	15	4	80	179
2011 он	4	21	9	-	47	162
2012 он	3	17	7	4	26	148
2013 он	2	9	5	-	76	141
2014 он	25	7	7	3	28	159
2015 он	98	4	1	1	21	253
2016 оны I улирал	21	3	1	0	11	271
Дүн	394	123	58	13	314	

ХЗХ-дын тооны өөрчлөлтийг сүүлийн 10 жилийн байдлаар харуулбал:



ХЗХ-дын гишүүдийн тооны өөрчлөлтийг харуулбал:



ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөл бүхий 271 ХЗХ-ны тоон үзүүлэлт нэгтгэлд бүрэн хамрагдсан байна.

2.1 Гишүүдийн статистик үзүүлэлтүүд

(тоогоор)

СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ	НИЙТ 271 ХЗХ-ДЫН ГИШҮҮДИЙН		ҮҮНЭЭС:			
			Улаанбаатар хот дахь 175 ХЗХ-дын		Орон нутаг дахь 96 ХЗХ-дын	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Гишүүдийн						
Нийт гишүүдийн тоо	41,817	100%	24,116	100%	17,701	100%
Үүнээс: эмэгтэй	24,136	57.7%	14,523	60.2%	9,613	54.3%
Үүнээс: гишүүн хуулийн этгээд	83	0.2%	71	0.3%	12	0.1%
Гишүүдийн насжилт	41,817	100%	24,116	100%	17,701	100%
18-35 насны	12,303	29.4%	7,321	30.4%	4,982	28.1%
36-45 насны	13,202	31.6%	7,225	30.0%	5,977	33.8%
46-55 насны	10,084	24.1%	5,700	23.6%	4,384	24.8%
55-аас дээш	6,228	14.9%	3,870	16.0%	2,358	13.3%
Гишүүдийн боловсрол	41,817	100%	24,116	100%	17,701	100%
Дээд	19,923	47.6%	14,058	58.3%	5,865	33.1%
Тусгай дунд	6,509	15.6%	3,781	15.7%	2,728	15.4%
Бүрэн дунд	9,105	21.8%	4,709	19.5%	4,396	24.8%
Дунд	4,917	11.8%	1,402	5.8%	3,515	19.9%
Бага	1,363	3.3%	166	0.7%	1,197	6.8%
Хадгаламж эзэмшигч гишүүдийн тоо	19,147	45.8%	10,699	44.4%	8,448	47.7%
Хугацаатай хадгаламжтай	14,710	35.2%	7,404	30.7%	7,306	41.3%
Хугацаагүй хадгаламжтай	4,437	10.6%	3,295	13.7%	1,142	6.5%
Зээлдэгч гишүүдийн тоо	20,981	50.2%	11,111	46.1%	9,870	55.8%
Хэвийн зээлтэй	19,263	46.1%	10,226	42.4%	9,037	51.1%
Хугацаа хэтэрсэн зээлтэй	987	2.4%	515	2.1%	472	2.7%
Чанаргүй:	731	2.1%	370	1.9%	361	2.04%
Хэвийн бус зээлтэй	338	0.8%	138	0.6%	200	1.1%
Эргэлзээтэй зээлтэй	199	0.5%	106	0.4%	93	0.5%
Муу	194	0.8%	126	0.9%	68	0.7%

Тайлант улиралд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 271 хоршоодын гишүүдийн тоо 41,817-д хүрсэн байгаа нь өмнөх оны мөн үеэс 9,039 гишүүнээр, өмнөх улирлаас 2,671 гишүүнээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Мөн нийт гишүүдийн 17,701 буюу 42.3 хувь нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа 96 ХЗХ-дын гишүүд, 24,116 буюу 57.7 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа 196 ХЗХ-дын гишүүд байгаа ба нийт гишүүдийн 19,147 буюу 45.8 хувь нь хадгаламж эзэмшигч гишүүд, 20,981 буюу 50.2 хувь нь зээлдэгч гишүүд байна.

2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд


(мянган төгрөгөөр)

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2015 оны I улирал	2016 оны I улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	ХЗХ-дын тоо	207	271	64	30.9%
2	Гишүүдийн тоо	32,778	41,817	9,039	27.6%
3	Нийт актив	85,768,698.0	101,526,431.9	15,757,733.9	18.4%
	<i>Банкны салбарт эзлэх хувь</i>	<i>0.4%</i>	<i>0.5%</i>	<i>0.1%</i>	
4	Нийт зээлийн үлдэгдэл	71,582,329.0	80,318,082.9	8,735,753.9	12.2%
	<i>Банкны салбарт эзлэх хувь</i>	<i>0.6%</i>	<i>0.7%</i>	<i>0.1%</i>	
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	1,965,428.0	3,457,100.7	1,491,672.7	75.9%
	<i>Банкны салбарт эзлэх хувь</i>	<i>0.3%</i>	<i>0.4%</i>	<i>0.1%</i>	
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл	56,663,428.0	62,808,344.1	6,144,916.1	10.8%
	<i>Банкны салбарт эзлэх хувь</i>	<i>0.8%</i>	<i>0.8%</i>	<i>0.0%</i>	
7	Нийт хувь хөрөнгийн үлдэгдэл	10,092,303.0	11,107,870.4	1,015,567.4	10.1%
8	Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл	8,049,666.0	9,365,709.0	1,316,043.0	16.3%
9	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн дүн	6,079,485.0	11,882,476.1	5,802,991.1	95.5%
10	Нийт орлого	5,045,748.0	6,077,367.5	1,031,619.5	20.4%
11	Нийт зардал	4,562,665.0	5,454,968.2	892,303.2	19.6%
12	Тухайн үеийн ашиг, алдагдал	483,083.0	622,399.3	139,316.3	28.8%

Тайлант улиралд ХЗХ-ны тоо өмнөх оны мөн үеэс 30.9 хувиар, гишүүдийн тоо 27.6 хувиар, нийт активын хэмжээ 18.4 хувиар тус тус өссөн байна. Нийт активын болон зээлийн хэмжээ өсч банкны салбарт эзлэх хувь нь тус бүр 0.1 хувиар өссөн нь "Бичил бизнесийг дэмжих ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр"-т 114 ХЗХ хамрагдсантай холбоотой бөгөөд төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн хэмжээ 11,882,476.1 мянган төгрөгт хүрсэн байна. Мөн ХЗХ-ны салбарын активын хэмжээ 100 тэрбум давсан нь салбарын хувьд анхны тохиолдол юм.

Мөн тайлант улиралд ХЗХ-ны салбарын чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 75.9 хувиар өссөн, тайлант үеийн цэвэр ашиг өмнөх оны мөн үеэс 139,316.3 мянган төгрөгөөр буюу 28.8 хувиар өссөн байна.

Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 271 ХЗХ-доос 64.6 хувь буюу 175 ХЗХ нь Улаанбаатар хотод, 35.4 хувь буюу 96 ХЗХ нь орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байгааг орон нутгийн байршлаар үзүүлбэл:



2.3 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2015 оны I улирал	2016 оны I улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	УБ хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо	124	175	51	41.1%
2	Гишүүдийн тоо	16,093	24,116	8,023	49.9%
	<i>ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь</i>	<i>49.0%</i>	<i>57.7%</i>	<i>8.67%</i>	<i>17.7%</i>
3	Нийт актив	73,497,239.7	87,192,391.4	13,695,151.7	18.6%
	<i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i>	<i>86.0%</i>	<i>85.9%</i>	<i>-0.12%</i>	<i>-0.1%</i>
4	Нийт зээлийн үлдэгдэл	61,725,702.5	69,138,567.3	7,412,864.8	12.0%
	<i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>86.0%</i>	<i>86.1%</i>	<i>0.08%</i>	<i>0.1%</i>
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	1,369,037.9	2,970,719.5	1,601,681.6	117.0%
	<i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>70.0%</i>	<i>85.9%</i>	<i>15.93%</i>	<i>22.8%</i>
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл	49,260,644.1	55,218,764.2	5,958,120.1	12.1%
	<i>ХЗХ-ны нийт хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>87.0%</i>	<i>87.9%</i>	<i>0.92%</i>	<i>1.1%</i>
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	7,039,289.3	7,881,261.5	841,972.2	12.0%
	<i>ХЗХ-ны нийт хувь хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>70.0%</i>	<i>71.0%</i>	<i>0.95%</i>	<i>1.4%</i>
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн	7,412,368.4	7,572,065.2	159,696.8	2.2%
	<i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i>	<i>92.0%</i>	<i>80.8%</i>	<i>-11.15%</i>	<i>-12.1%</i>
9	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн дүн	5,179,782.90	11,832,549.5	6,652,766.6	128.4%
10	Нийт орлого	4,047,910.10	4,793,800.2	745,890.1	18.4%
11	Нийт зардал	3,729,206.30	4,161,400.1	432,193.8	11.6%
12	Тухайн үеийн ашиг, алдагдал	318,703.70	632,400.1	313,696.4	98.4%

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 175 ХЗХ-дын нийт актив 87,192,391.4 мянган төгрөг байгаа нь салбарын нийт активын 85.9 хувийг, нийт орлого 4,793,800.2 мянган төгрөг байгаа нь ХЗХ-дын нийт орлогын 78.9 хувийг, нийт зардал 4,161,400.1 мянган төгрөг байгаа нь нийт зардлын 76.3 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант улиралд Нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа ХЗХ-дын тоо нэмэгдэж нийт активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 18.6 хувиар, нийт зээлийн хэмжээ 7,412,864.8 мянган төгрөгөөр буюу 12.0 хувиар өсөхөд "Бичил бизнесийг дэмжих ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр"-ийн хямд өртөг бүхий санхүүжилт гол нөлөө үзүүлсэн гэж дүгнэж байна.

2.4 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2015 оны I улирал	2016 оны I улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо	83	96	13	15.7%
2	Гишүүдийн тоо	16,685.0	17,701	1,016	6.1%
	<i>ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь</i>	<i>50.0%</i>	<i>42.3%</i>	<i>-7.7%</i>	<i>-15.3%</i>
3	Нийт актив	12,271,458.5	14,334,040.5	2,062,582.0	16.8%
	<i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i>	<i>14.0%</i>	<i>14.1%</i>	<i>0.1%</i>	<i>0.8%</i>
4	Нийт зээлийн үлдэгдэл	9,856,626.3	11,179,515.5	1,322,889.2	13.4%
	<i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>14.0%</i>	<i>13.9%</i>	<i>-0.1%</i>	<i>-0.6%</i>

5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	258,979.7	486,381.1	227,401.4	87.8%
	<i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>13.0%</i>	<i>14.1%</i>	<i>1.1%</i>	<i>8.2%</i>
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл	6,105,921.5	7,589,579.9	1,483,658.4	24.3%
	<i>ХЗХ-ны нийт хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>11.0%</i>	<i>12.1%</i>	<i>1.1%</i>	<i>9.9%</i>
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	3,090,851.1	3,226,608.9	135,757.8	4.4%
	<i>ХЗХ-ны нийт хувь хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>31.0%</i>	<i>29.0%</i>	<i>-2.0%</i>	<i>-6.3%</i>
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн	1,471,843.6	1,793,643.8	321,800.2	21.9%
	<i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i>	<i>18.0%</i>	<i>19.2%</i>	<i>1.2%</i>	<i>6.4%</i>
9	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн дүн	899,701.9	49,926.6	-849,775.3	-94.5%
10	Нийт орлого	997,837.9	1,283,567.2	285,729.3	28.6%
11	Нийт зардал	833,458.3	1,293,568.1	460,109.8	55.2%
12	Тухайн үеийн ашиг	164,379.6	-10,000.9	-174,380.5	-106.1%

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 96 ХЗХ-дын нийт актив 14,334,040.5 мянган төгрөг байгаа нь салбарын нийт активын 14.1 хувийг, нийт орлого 1,283,567.2 мянган төгрөг байгаа нь нийт орлогын 21.1 хувийг, нийт зардал 1,293,568.1 мянган төгрөг байгаа нь нийт зардлын 23.7 хувийг тус тус эзэлж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-доос төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх зөвшөөрөлтэй 2 ХЗХ байгаа нь Дорнод аймгийн “Ноён даамал” ХЗХ, Хэнтий аймгийн “Зоос хүрд” ХЗХ-оод байна.

2.5 Нийслэлийн “Бичил бизнесийг дэмжих ядуурлыг бууруулах хөтөлбөр”-ийг дагнан хэрэгжүүлж буй 107 ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд (мянган төгрөгөөр)

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2015 оны IV улирал	2016 оны I улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	ХЗХ-дын тоо	107	107	-	-
2	Гишүүдийн тоо	6,257	7,021	764	12.2%
	<i>ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь</i>	<i>16.0%</i>	<i>16.8%</i>	<i>0.8%</i>	<i>-</i>
3	Нийт актив	9,923,642.90	10,709,566.5	785,924	7.9%
	<i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i>	<i>10.2%</i>	<i>10.5%</i>	<i>0.3%</i>	<i>-</i>
4	Нийт зээлийн үлдэгдэл	9,197,488.10	9,941,691.9	744,204	8.1%
	<i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>12.2%</i>	<i>12.4%</i>	<i>0.2%</i>	<i>-</i>
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	58,585.40	195,143.1	136,558	233.1%
	<i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>1.7%</i>	<i>5.6%</i>	<i>3.9%</i>	<i>-</i>
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл	356,025.80	458,410.7	102,385	28.8%
	<i>ХЗХ-ны нийт хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>0.6%</i>	<i>0.7%</i>	<i>0.1%</i>	<i>-</i>
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	421,131.80	478,844.4	57,713	13.7%
	<i>ХЗХ-ны нийт хувь хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	<i>4.0%</i>	<i>4.3%</i>	<i>0.3%</i>	<i>-</i>
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн	-145,304.90	-152,550.6	-7,246	5.0%
	<i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i>	<i>-1.4%</i>	<i>-1.6%</i>	<i>-0.2%</i>	<i>-</i>
9	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн дүн	9,172,221.90	9,806,664.8	624,423	6.9%
	<i>ХЗХ-ны нийт авсан зээлийн дүнд эзлэх хувь</i>	<i>73.10%</i>	<i>82.5%</i>	<i>9.4%</i>	<i>-</i>
10	Нийт орлого	749,760.10	432,456.2	-317,304	-42.3%
11	Нийт зардал	890,815.30	487,608.8	-403,207	-45.3%

12	Тухайн үеийн ашиг	-141,055.10	-55,152.6	85,903	-60.9%
----	-------------------	-------------	-----------	--------	--------

Хорооноос төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх зөвшөөрөл авсан 114 ХЗХ байгаагаас Бичил бизнесийг дэмжих Нийслэлийн төслийн зээлийн санхүүжилтэд хамрагдсан 107 ХЗХ уг төслөөс 9,805,105.0 мянган төгрөгийн зээл авсан байна.

Тайлант жилд дээрх 107 ХЗХ-оос 58 ХЗХ нь 85,238.1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь салбарын нийт алдагдлын 21.1 хувьтай тэнцэж байна. Тус ХЗХ-дын нийт хүүгийн орлого 391,157.9 мянган төгрөг байхад үйл ажиллагааны зардал 402,469.8 мянган төгрөг байгааг анхаарах хэрэгтэй байна.

ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1 Хөрөнгийн бүтэц

ХЗХ-дын тайлант улирлын нийт хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд: (мянган төгрөгөөр)

№	ХӨРӨНГӨ	3/31/2015		3/31/2016		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		83,486,614.0	97.3%	99,292,821.6	97.8%	15,806,207.7	18.9%
1.1	МӨНГӨН ХӨРӨНГӨ	10,203,264.2	11.9%	16,596,007.1	16.3%	6,392,742.9	62.7%
	Бэлэн мөнгө	2,557,743.7	3.0%	1,836,207.3	1.8%	(721,536.4)	-28.2%
	Банкинд байршуулсан харилцах	3,055,092.0	3.6%	2,998,204.6	3.0%	(56,887.4)	-1.9%
	Банкинд байршуулсан хадгаламж	4,590,428.5	5.4%	11,761,595.2	11.6%	7,171,166.8	156.2%
1.2	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	0.0%	-	0.0%	-	-
	Арилжааны үнэт цаас	-	0.0%	-	0.0%	-	-
1.3	ЗЭЭЛ /ЦЭВРЭЭР/	70,070,605.7	81.7%	78,198,418.3	77.0%	8,127,812.6	11.6%
	Нийт зээл	71,582,328.8	83.5%	80,318,082.9	79.1%	8,735,754.1	12.2%
	Хэвийн зээл	67,426,126.2	78.6%	73,194,302.4	72.1%	5,768,176.2	8.6%
	Хугацаа хэтэрсэн зээл	2,190,774.6	2.6%	3,666,679.8	3.6%	1,475,905.2	67.4%
	Чанаргүй зээл	1,965,428.0	2.3%	3,457,100.7	3.4%	1,491,672.7	75.9%
	Хэвийн бус зээл	748,168.9	0.9%	1,337,137.9	1.3%	588,969.0	78.7%
	Эргэлзээтэй зээл	790,387.4	0.9%	1,059,290.8	1.0%	268,903.4	34.0%
	Муу зээл	426,871.7	0.5%	1,060,672.0	1.0%	633,800.3	148.5%
	(Зээлийн эрсдэлийн сан)	1,511,723.1	1.8%	2,119,664.6	2.1%	607,941.5	40.2%
1.4	АВЛАГА	2,409,664.1	2.8%	3,546,559.4	3.5%	1,136,895.3	47.2%
	Байгууллага, хүмүүсээс авах авлага	185,603.7	0.2%	238,290.1	0.2%	52,686.4	28.4%
	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	2,224,060.5	2.6%	3,308,269.4	3.3%	1,084,208.9	48.7%
1.5	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	223,543.4	0.3%	308,640.6	0.3%	85,097.2	38%
	Татварын авлага	7,529.2	0.0%	18,147.3	0.0%	10,618.1	141%
	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	21,598.0	0.0%	48,352.4	0.0%	26,754.3	123.9%
	Дараа тайлангийн тооцоо	26,657.0	0.0%	57,847.6	0.1%	31,190.6	117.0%
	Дутагдал, шамшигдал	114,514.7	0.1%	115,207.2	0.1%	692.5	-
	Хангамжийн зүйлс	53,244.4	0.1%	69,086.1	0.1%	15,841.7	29.8%
	Салбар хоорондын авлага	-	0.0%	-	0.0%	-	-
1.6	ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ /ЦЭВРЭЭР/	579,536.5	0.7%	643,196.2	0.6%	63,659.7	11.0%
	Өмчлөх бусад хөрөнгө	621,651.7	0.7%	733,150.5	0.7%	111,498.7	17.9%
	(Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулга)	42,115.2	0.0%	89,954.3	0.1%	47,839.1	113.6%
2. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		2,282,084.3	2.7%	2,233,610.3	2.2%	(48,474.0)	-2.1%
2.1	ҮНДСЭН ХӨРӨНГӨ /ЦЭВРЭЭР/	2,258,212.8	2.6%	2,209,828.1	2.2%	(48,384.7)	-2.1%

	Үндсэн хөрөнгө	2,764,136.5	3.2%	2,797,201.9	2.8%	33,065.4	1.2%
	(Хуримтлагдсан элэгдэл)	505,923.7	0.6%	587,373.8	0.6%	81,450.1	16.1%
2.2	БИЕТ БУС ХӨРӨНГӨ	8,851.5	0.0%	8,762.2	0.0%	(89.3)	-1.0%
	Биет бус хөрөнгө	14,007.0	0.0%	10,741.3	0.0%	(3,265.7)	-23.3%
	(Биет бус хөрөнгийн элэгдэл)	5,155.5	0.0%	1,979.2	0.0%	(3,176.3)	-62%
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	15,020.0	0.0%	15,020.0	0.0%	-	-
2.3	Хөрөнгө оруулалт ба бусад эргэлтийн бус хөрөнгө	15,020.0	0.0%	15,020.0	0.0%	-	-
	ХӨРӨНГИЙН ДҮН	85,768,698.2	100%	101,526,431.9	100%	15,757,733.7	18.4%


Активын хэмжээ өмнөх онтой харьцуулахад 18.4 хувиар буюу 15,757,733.7 мянган төгрөгөөр өссөн.

ХЗХ-дын банкинд байршуулсан хадгаламжийн хэмжээ 7,171,166.8 мянган төгрөгөөр буюу 156.8 хувиар өсч нийт банкинд байршуулсан хадгаламжийн хэмжээ 11,761,595.2 мянган төгрөг болсон байна. Санхүүгийн байгууллагын хувьд гишүүдээсээ хүүтэй татсан эх үүсвэрийг зээлд гаргахгүй байгаа нь учир дутагдалтай гэж үзэж байна.

Тайлант улиралд чанаргүй зээлийн хэмжээ 1,491,672.7 мянган төгрөгөөр буюу өмнөх оны мөн үеэс 75.9 хувиар өссөн, үүнийг дагаад зээлийн эрсдэлээс хамгаалах сан 607,941.5 мянган төгрөгөөр буюу 40.2 хувиар өссөн байгааг анхаарч зээлийн чанар муудаж байгаа ХЗХ-дод хяналтыг сайжруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Хөрөнгө оруулалт ба бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэгдсэн 15,020.0 мянган төгрөгийн үлдэгдэл нь "Монкорд" ХЗХ-ны дансанд бүртгэлтэй дундын хоршооноос авах авлага /2010 оноос хойш/ бүртгэгдсэн байна.

Хадгаламж, зээлийн хоршоодын тоо болон нийт активын өөрчлөлтийг харьцуулж үзүүлбэл :



3.2 Активын төвлөрлийг активын хэмжээ болон байрилаар нь авч үзвэл

Үүнд: Активын хэмжээгээр:


(мянган төгрөгөөр)

№	Активын хэмжээ	ХЗХ-дын тоо	Нийт актив		Гишүүдийн тоо		Байршил	
			Дүн	Хувь	Тоо	Хувь	УБ	Орон нутаг
1	10,000,000.0 дээш	2	41,985,111.5	41.35%	5,138	12.29%	2	
2	1,000,000.0-10,000,000.0	12	30,658,437.2	30.20%	8,646	20.68%	10	2
3	500,000.0-1,000,000.0	7	4,805,518.6	4.73%	3,573	8.54%	3	4
4	100,000.0-500,000.0	134	20,444,989.9	20.14%	17,485	41.81%	102	32
5	50,000.0-100,000.0	31	2,274,535.8	2.24%	3,060	7.32%	15	16
6	10,000.0-50,000.0	42	1,233,308.4	1.21%	2,721	6.51%	17	25
7	10,000.0 хүртэл	43	124,530.5	0.12%	1,194	2.86%	26	17
	Нийт дүн	271	101,526,431.9	100%	41,817	100%	175	96

ХЗХ-дын активын төвлөрлийг ангилахад томоохон буюу 1 тэрбум төгрөгөөс дээш актив хөрөнгөтэй 14 ХЗХ-ны нийт актив 72,643,548.7 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын активын 71.5 хувийг, гишүүдийн тоо 13,784 байгаа нь нийт ХЗХ-дын гишүүдийн 33.0 хувийг тус тус эзэлж байна.

3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар


Зээлийн чанарыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:



Цэвэр зээлийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8,127,812.6 мянган төгрөгөөр буюу 11.6 хувиар өссөн бол хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 1,475,905.2 мянган төгрөгөөр буюу 67.4 хувиар, чанаргүй зээлийн үлдэгдэл 1,491,672.7 мянган төгрөгөөр буюу 75.9 хувиар өссөн байна.

Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үед 2.5 хувь байсан бол тайлант улиралд 4.3 хувь болж өссөн байна.

Зээлийн багцын өөрчлөлтийг харьцуулж харуулбал: (тэрбум төгрөгөөр)



ХЗХ-дын нийт зээлийн багц 80,318,082.9 мянган төгрөг байгаа нь активын 79.1 хувьтай, цэвэр зээл 78,198,418.3 мянган төгрөг байгаа нь активын 77.0 хувьтай тус тус тэнцэж байна.

ХЗХ-дын тайлант онд олгосон төлөгдсөн зээл дараах байдалтай байна. Үүнд: (мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Нийт 271 ХЗХ	ҮҮНЭЭС:	
		Улаанбаатар хот	Орон нутаг
Зээлийн эхний үлдэгдэл	73,247,887.4	63,201,257.8	10,046,629.6
Олгосон зээл	73,541,019.0	67,186,987.4	6,354,031.7
Төлөгдсөн зээл	66,470,823.6	61,249,677.9	5,221,145.7

Зээлийн эцсийн үлдэгдэл	80,318,082.9	69,138,567.3	11,179,515.5
--------------------------------	---------------------	---------------------	---------------------

ХЗХ-д 2015 оны жилийн эцэст 73,247,887.7 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант улиралд нийт 73,541,019.0 мянган төгрөгийн зээл олгож, 66,470,823.6 мянган төгрөгийн зээл төлөгдөж, 2016 оны 1 дүгээр улирлын байдлаар 20,981 гишүүний 80,318,082.9 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй болсон байна.

Тайлант улиралд олгосон зээлийг зориулалтаар нь ангилвал дараах байдалтай байна.
Үүнд: (мянган төгрөгөөр)

Олгосон зээлийн зориулалт	Зээлийн хэмжээ	Тоо	Хувь
Нийт зээл	73,541,019.1	10,828	100.0%
Үүнээс: Иргэнд олгосон	35,604,360.1	10,581	48.4%
Хуулийн этгээдэд олгосон	37,936,658.9	247	51.6%
Бизнесийн зээл	65,542,580.2	5,553.00	89.1%
1. Үйлдвэрлэлийн зээл	5,395,283.9	1,463.00	7.3%
2. Үйлчилгээний зээл	55,471,641.9	2,455.00	75.4%
3. Газар тариалангийн зээл	163,482.60	56.00	0.2%
4. Мал аж ахуйн зээл	979,643	825.00	1.3%
5. Бусад	3,532,528.68	754.00	4.8%
Хэрэглээний зээл	7,998,438.9	5,275.00	10.9%
1. Өрхийн зээл	4,470,528.5	3,884.00	6.1%
2. Сургалтын төлбөрийн зээл	997,806.6	269.00	1.4%
3. Бусад	2,530,103.7	1,122.00	3.4%
Зээлийн үлдэгдэл	80,318,082.9	20,981.00	100%

Нийт олгосон зээлийн 48.4 хувь буюу 35,604,360.1 мянган төгрөгийг 10,581 иргэнд, 51.6 хувь буюу 37,936,658.9 мянган төгрөгийг 247 хуулийн этгээдэд олгосон байна. Мөн нийт зээлийн 89.1 хувь буюу 65,542,580.2 мянган төгрөгийг бизнесийн зориулалттай олгосон бол 10.9 хувь буюу 7,998,438.9 мянган төгрөгийг хэрэглээний зээлд зориулан олгосон байна.

ДӨРӨВ. НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

4.1 Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн талаар


Тайлант улирлын нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Үүнд: (мянган төгрөгөөр)

№	ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3/31/2015		3/31/2016		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1.	ӨР ТӨЛБӨР	67,228,097.3	78.4%	81,001,547.3	79.8%	13,773,450.0	20.5%
1.1	ХАДГАЛАМЖ	56,663,427.8	66.1%	62,808,344.1	61.9%	6,144,916.3	10.8%
	Хугацаагүй	1,308,377.5	1.5%	2,236,258.5	2.2%	927,881.0	70.9%
	Хугацаатай	55,355,050.3	64.5%	60,572,085.6	59.7%	5,217,035.4	9.4%
1.2	БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ	3,750,481.7	4.4%	1,379,781.9	1.4%	(2,370,699.8)	-63.2%
	Банкнаас авсан зээл	2,456,454.3	2.9%	614,145.3	0.6%	(1,842,309.0)	-75.0%
	Санхүүгийн байгууллагаас авсан зээл	587,110.2	0.7%	400,210.0	0.4%	(186,900.2)	-31.8%
	Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	706,917.2	0.8%	365,426.6	0.4%	(341,490.6)	-48.3%
	Тогтворжилтын сангийн санхүүгийн туслалцаа	-	0.0%	-	0.0%	-	0.0%
1.3	БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,485,184.5	5.2%	4,843,749.9	4.8%	358,565.4	8.0%
	Цалингийн өглөг	40,660.4	0.0%	43,031.7	0.0%	2,371.3	5.8%
	Татвар, НДШ, ЭМДШ-ийн өглөг	193,957.9	0.2%	236,638.5	0.2%	42,680.7	22.0%
	Ногдол ашгийн өглөг	555,980.8	0.6%	444,958.1	0.4%	(111,022.7)	-20.0%
	Санхүүгийн түрээсийн өглөг	915.0	0.0%	-	0.0%	(915.0)	-100.0%
	Санхүүгийн түрээсийн	12.5	0.0%	-	0.0%	(12.5)	-

	хэрэгжээгүй орлого						
	Урьдчилж орсон орлого	36,201.2	0.0%	27,434.8	0.0%	(8,766.4)	-24.2%
	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	3,584,646.7	4.2%	3,957,933.8	3.9%	373,287.1	10.4%
	Салбар хоорондын тооцоогоорх өглөг	4,523.8	0.0%	-	0.0%	(4,523.8)	-100.0%
	Бусад богино хугацаат өглөг	68,286.3	0.1%	133,753.1	0.1%	65,466.8	95.9%
1.4	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,329,003.2	2.7%	11,969,671.3	11.8%	9,640,668.2	413.9%
	Банкнаас авсан зээл	325,166.4	0.4%	294,627.2	0.3%	(30,539.2)	-9.4%
	Санхүүгийн байгууллагаас авсан зээл	414,840.3	0.5%	154,479.4	0.2%	(260,360.9)	-62.8%
	Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	1,586,622.7	1.8%	11,517,049.5	11.3%	9,930,426.8	625.9%
	Тогтворжилтын сангийн санхүүгийн туслалцаа	-	0.0%	-	0.0%	-	-
	Хойшлогдсон татварын өр төлбөр	2,373.8	0.0%	3,515.3	0.0%	1,141.4	48.1%
	2. ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	18,540,601.0	21.6%	20,524,884.6	20.2%	1,984,283.7	10.7%
2.1	ГИШҮҮДИЙН ОРУУЛСАН ХУВЬ ХӨРӨНГӨ	10,112,705.6	11.8%	11,107,870.4	10.9%	995,164.8	9.8%
	Гишүүний оруулсан хувь хөрөнгө	10,092,302.8	11.8%	11,082,206.5	10.9%	989,903.7	9.8%
	Идэвхгүй гишүүний оруулсан хувь хөрөнгө	20,402.8	0.0%	25,663.9	0.0%	5,261.1	25.8%
2.2	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ	378,229.1	0.4%	51,305.2	0.1%	(326,923.9)	-86.4%
	Дахин үнэлгээний нэмэгдэл	378,229.1	0.4%	51,305.2	0.1%	(326,923.9)	-86.4%
2.3	ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ	8,049,666.3	9.4%	9,365,709.0	9.2%	1,316,042.8	16.3%
	Нөөцийн сан	2,570,009.4	3.0%	2,733,768.3	2.7%	163,758.8	6.4%
	Хандив, тусламж	21,050.1	0.0%	78,696.0	0.1%	57,645.9	273.9%
	Хадгаламж, хамгаалалтын сан	730,746.1	0.9%	669,650.3	0.7%	(61,095.9)	-8%
	Нийгмийн хөгжлийн сан	440,431.3	0.5%	627,054.6	0.6%	186,623.3	42.4%
	Тогтворжилтын сан	560,913.4	0.7%	675,430.9	0.7%	114,517.5	-
	Бусад сангууд	833,824.4	1.0%	815,090.9	0.8%	(18,733.5)	-2.2%
	Хуримтлагдсан орлого /алдагдал/	2,892,691.5	3.4%	3,766,018.0	3.7%	873,326.6	30.2%
	Тайлангийн үеийн цэвэр орлого	483,083.4	0.6%	622,399.3	0.6%	139,315.8	28.8%
	Өмнөх үеийн цэвэр орлого	2,409,608.0	2.8%	3,143,618.8	3.1%	734,010.7	30.5%
	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	85,768,698.2	100%	101,526,431.9	100%	15,757,733.7	18.4%

ХЗХ-дын өр төлбөр, өөрийн хөрөнгийн хэмжээ буюу эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15,757,733.7 мянган төгрөгөөр буюу 18.4 хувиар өссөн. Энэ өсөлтөд төсөл хөтөлбөрөөс авсан урт хугацаат зээлийн хэмжээ 9,930,426.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн өөрчлөлтийг харьцуулж үзүүлбэл: (тэрбум төгрөгөөр)



4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 62,808,344.1 мянган төгрөг буюу нийт эх үүсвэрийн 61.9 хувийг эзэлж байгаа бөгөөд үүний 60,572,085.6 мянган төгрөг буюу 96.4 хувь нь хугацаатай хадгаламж байгаа бол 2,236,258.5 мянган төгрөг буюу 3.6 хувь нь хугацаагүй хадгаламж байна.

Үүнийг бүлэглэн харуулбал:

(мянган төгрөгөөр)

№	Хадгаламжийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хадгаламжийн дүн	Нийт хадгаламжид эзлэх хувь	Хадгаламж эзэмшигч гишүүдийн тоо
1	10,000,000.0 дээш	1	23,711,215.0	37.8%	1,285
2	1,000,000.0-10,000,000.0	10	28,299,661.9	45.1%	4,241
3	500,000.0-1,000,000.0	3	1,752,789.0	2.8%	657
4	100,000.0-500,000.0	27	6,051,075.2	9.6%	4,378
5	50,000.0-100,000.0	16	1,172,954.6	1.9%	1,830
6	10,000.0-50,000.0	58	1,389,402.5	2.2%	3,429
7	5,000.0-10,000.0	38	252,776.5	0.4%	1,318
8	5,000.0 хүртэл	76	178,469.4	0.3%	2,009
9	Хадгаламжгүй	42	-	0.0%	
Нийт хадгаламжийн дүн		271	62,808,344.1	100%	19,147

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад 1,000,000.0 мянган төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй 11 ХЗХ-ны хадгаламжийн үлдэгдэл 52,010,877.0 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын хадгаламжийн үлдэгдлийн 82.8 хувийг эзэлж байгаа бол хадгаламж татан төвлөрүүлээгүй 42 ХЗХ байгаа нь нийт ХЗХ-дын 15.5 хувийг эзэлж байна.

Салбарын хэмжээгээр нийт хадгаламжийн өсөлтийг харуулбал:

(тэрбум төгрөгөөр)

**4.3 Бусдаас авсан зээл**

(мянган төгрөгөөр)

№	Бусдаас авсан зээл	Нийт	УБ хот	Орон нутаг
			Дүн	Дүн
1	Банкнаас авсан зээл	908,772.46	279,036.01	629,736.45
2	Санхүүгийн байгууллагаас авсан зээл	554,689.41	324,479.41	230,210.00
3	Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	11,882,476.09	11,832,549.50	49,926.59

4.4 Хувь хөрөнгийн талаар

Тайлант улиралд гишүүдийн хувь хөрөнгийн хэмжээ 11,107,870.4 мянган төгрөг байгаа нь нийт эх үүсвэрийн 10.9 хувийг эзэлж байна. Үүнийг интервалаар харуулбал:

(мянган төгрөгөөр)

д/д	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Гишүүдийн тоо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн	
				Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	2	4,599	3,510,726.4	31.61%
2	500,000.0-1,000,000.0	1	319	645,122.0	5.81%
3	100,000.0-500,000.0	16	10,525	2,911,176.7	26.21%
4	50,000.0-100,000.0	23	7,044	1,669,993.1	15.03%

5	10,000.0-50,000.0	78	10,768	1,797,851.0	16.19%
6	5,000.0-10,000.0	41	3,060	269,059.7	2.42%
7	5,000.0 хүртэл	110	5,502	303,941.5	2.74%
Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн		271	41,817	11,107,870.4	100%

ХЗХ-дын хувь хөрөнгийн өсөлтийг өмнөх жилүүдтэй харьцуулвал: (тэрбум төгрөгөөр)



4.5 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар

2016 оны 1 дүгээр улирлын байдлаар ХЗХ-дын өөрийн хөрөнгө 20,524,884.6 мянган төгрөг байгаа нь нийт эх үүсвэрийн 20.2 хувийг эзэлж байна. Үүнийг бүлэглэн харуулбал дараах байдалтай байна. (мянган төгрөгөөр)

д/д	Өөрийн хөрөнгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Өөрийн хөрөнгө	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	3	8,856,146.0	43.15%
2	500,000.0-1,000,000.0	4	2,319,721.0	11.30%
3	100,000.0-500,000.0	28	5,583,822.0	27.21%
4	50,000.0-100,000.0	22	1,574,990.7	7.67%
5	10,000.0-50,000.0	70	1,845,166.3	8.99%
6	10,000.0 доош	121	414,592.1	2.02%
7	Өөрийн хөрөнгөгүй	23	-69,553.5	-0.34%
Нийт өөрийн хөрөнгийн дүн		271	20,524,884.6	100%

ХЗХ-дын хоршоологчдын өмчийн байдлыг бүлэглэн харуулбал. Үүнд: (мянган төгрөгөөр)

д/д	Хоршоологчдын өмчийн дүн /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хоршоологчдын өмчийн дүн	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	1	3,856,348.4	41.18%
2	500,000.0-1,000,000.0	1	806,897.5	8.62%
3	100,000.0-500,000.0	14	3,068,762.0	32.77%
4	50,000.0-100,000.0	9	623,410.9	6.66%
5	10,000.0-50,000.0	51	1,170,412.9	12.50%
6	5,000.0-10,000.0	16	118,450.2	1.26%
7	1,000.0-5,000.0	36	103,996.2	1.11%
8	1,000.0 хүртэл	25	14,210.9	0.15%
9	Хоршоологчдын өмчгүй /алдагдалтай/	118	-396,780.1	-4.24%
Нийт дүн		271	9,365,709.0	100%

Алдагдалтай ажилласны улмаас хоршоологчдын өмчгүй болсон 118 ХЗХ байна.

ТАВ. ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**5.1 ХЗХ-дын орлогын үзүүлэлтүүд**

Орлогын бүтцийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд: (мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	3/31/2015		3/31/2016		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
I ХҮҮГИЙН ОРЛОГО	4,882,808.2	96.8%	5,862,272.9	96.5%	979,464.7	20.1%
Зээлийн хүүгийн орлого	4,682,822.3	92.8%	5,658,446.0	93.1%	975,623.7	20.8%
Зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого	54,800.8	1.1%	77,154.8	1.3%	22,354.0	40.8%
Үнэт цаасны хүүгийн орлого	107.4	0.0%	-	0.0%	(107.4)	-100.0%
Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого	164,004.8	3.3%	161,704.7	2.7%	(2,300.1)	-1.4%
Санхүүгийн түрээсийн хүүгийн орлого	889.8	0.0%	-	0.0%	(889.8)	-0.1%
(Зээлийн хүүгийн орлогын буцаалт)	19,816.8	0.4%	35,032.5	0.6%	15,215.7	76.8%
IV ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО	92,933.8	1.8%	123,512.8	2.0%	30,579.0	32.9%
Элсэлтийн хураамж	8,167.5	0.2%	18,960.5	0.3%	10,793.0	132.1%
Гишүүний татвар	11,226.0	0.2%	21,217.2	0.3%	9,991.2	89.0%
Үйлчилгээний шимтгэл, хураамж	64,422.0	1.3%	81,269.3	1.3%	16,847.2	26.2%
Түрээсийн орлого	5,405.0	0.1%	2,065.9	0.0%	(3,339.1)	-61.8%
Санхүүгийн бусад ажил, үйлчилгээний орлого	3,713.3	0.1%	-	0.0%	(3,713.3)	-100.0%
VI ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	70,006.0	1.4%	91,581.8	1.5%	21,575.8	30.8%
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	8,485.5	0.2%	440.5	0.0%	(8,045.0)	-94.8%
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	139.2	0.0%	-	0.0%	(139.2)	-100.0%
Үнэт цаасны арилжааны орлого	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Торгуулийн орлого	0.4	0.0%	-	0.0%	(0.4)	0.0%
Бусад орлого	61,380.8	1.2%	91,141.2	1.5%	29,760.4	48.5%
НИЙТ ОРЛОГО	5,045,748.0	100%	6,077,367.5	100%	1,031,619.4	20.4%

ХЗХ-дын нийт орлого өмнөх оны мөн үеэс 1,031,619.4 мянган төгрөгөөр буюу 20.4 хувиар өсөж 6,077,367.5 мянган төгрөгт хүрсэн байна. Энэхүү өсөлтөд зээлийн хүүгийн орлого 975,623.7 мянган төгрөгөөр буюу 20.8 хувиар, үйл ажиллагааны бусад орлого 30,579.0 мянган төгрөгөөр буюу 32.9 хувиар, үйл ажиллагааны бус орлого 21,575.8 мянган төгрөгөөр буюу 30.8 хувиар тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

5.2 ХЗХ-дын зардлын үзүүлэлтүүд


Зардлын бүтцийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд: (мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	3/31/2015		3/31/2016		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
II ХҮҮГИЙН ЗАРДАЛ	2,666,217.3	58.4%	3,079,560.7	56.5%	413,343.4	15.5%
Хадгаламжийн хүүгийн зардал	2,598,936.0	57.0%	2,948,228.9	54.0%	349,292.9	13.4%
Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	77,988.1	1.7%	111,372.5	2.0%	33,384.4	42.8%
Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал	1,807.8	0.0%	250.0	0.0%	(1,557.8)	-86.2%
Бусад хүүгийн зардал	1,143.7	0.0%	19,887.6	0.4%	18,743.9	1638.9%
(Хүүгийн зардлын буцаалт)	13,658.2	0.3%	178.2	0.0%	(13,480.0)	-98.7%
III БОЛЗОШГУЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ	461,123.7	10.1%	248,096.5	4.5%	(213,027.2)	-46.2%
Зээлийн эрсдэлийн зардал	428,262.6	9.4%	292,305.7	5.4%	(135,956.9)	-31.7%

Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулгын зардал	39,191.1	0.9%	1,088.8	0.0%	(38,102.3)	-97.2%
(Болзошгүй эрсдэлийн сангийн нөхөлт)	6,330.0	0.1%	45,298.0	0.8%	38,968.0	615.6%
V ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,332,641.8	29.2%	1,832,791.9	33.6%	500,150.1	37.5%
Боловсон хүчний зардал	843,956.7	18.5%	1,161,005.7	21.3%	317,049.0	37.6%
Бусад төрлийн зардал	488,685.0	10.7%	671,786.2	12.3%	183,101.1	37.5%
VI ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	16,758.9	0.4%	181,181.8	3.3%	164,422.9	981.1%
IX ТАТВАРЫН ЗАРДАЛ	85,922.9	1.9%	113,337.3	2.1%	27,414.4	31.9%
НИЙТ ЗАРДАЛ	4,562,664.6	100%	5,454,968.2	100%	892,303.6	19.6%
НИЙТ АШИГ	483,083.4	100%	622,399.3	100%	139,315.8	28.8%

ХЗХ-дын нийт зардлын хэмжээ 5,454,968.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 892,303.6 мянган төгрөгөөр буюу 19.6 хувиар өссөн байна.

5.3 Ашигт ажиллагааг өмнөх жилүүдтэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:



5.4 Ашигтай ажиллаж буй ХЗХ-д

Тайлант улиралд 178 ХЗХ-д 1,026,235.0 мянган төгрөгийн ашигтай, 31 ХЗХ ашиг, алдагдалгүй, 93 ХЗХ 403,835.7 мянган төгрөгийн алдагдалтай тус тус ажиллаж салбарын хэмжээнд нийт 622,399.3 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Салбарын ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 139,315.8 мянган төгрөгөөр буюу 28.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Ашигтай ажилласан ХЗХ-дыг бүлэглэн харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

(мянган төгрөгөөр)

Ашгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Ашгийн хэмжээ	Нийт ашигт эзлэх хувь	Активын хэмжээ	Активын өгөөж
100,000.0 дээш	2	486,455.2	47.4%	37,732,815.7	1.29%
50,000.0-100,000.0	-	-	-	-	-
10,000.0-50,000.0	16	326,808.0	31.8%	25,071,917.9	1.30%
5,000.0-10,000.0	12	88,659.1	8.6%	5,954,460.3	1.49%
1,000.0-5,000.0	43	92,805.1	9.0%	12,630,408.4	0.73%
1,000.0 хүртэл	74	31,507.6	3.1%	6,661,855.9	0.47%
Ашиг, алдагдалгүй	31	-	0.0%	511,365.4	0.00%
Нийт дүн	178	1,026,235.0	100%	88,562,823.7	1.16%

5.5 Алдагдалтай ажиллаж буй ХЗХ-д

Нийт 271 ХЗХ-дын 34.3 хувь буюу 93 ХЗХ 403,835.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Үүнд: (мянган төгрөгөөр)

д/д	Алдагдлын хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо		Алдагдлын хэмжээ	Нийт алдагдалд эзлэх хувь
		УБ	Орон нутаг		
1	10,000.0 дээш	4	3	-284,623.1	70.48%
2	5,000.0-10,000.0 хүртэл	4	3	-41,400.5	10.25%
3	1,000.0-5,000.0 хүртэл	24	5	-58,914.8	14.59%
4	1,000.0 хүртэл	41	9	-18,897.4	4.68%
	Нийт дүн	73	20	-403,835.7	100%

Алдагдалтай ажиллаж байгаа ХЗХ-дын 78.5 хувь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна. "Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр"-г хамрагдсан 107 ХЗХ-доос 54.2 хувь нь буюу 58 ХЗХ нь 85,238.1 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж байгаа нь нийт алдагдлын 21.1 хувийг эзэлж байна.

ЗУРГАА. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР

ХЗХ-дын 2016 оны 01 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 2014 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон дагаж мөрдөх үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

д/д	ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	ЗХШҮ/ДМУ	БАЙВАЛ ЗОХИХ	ТАЙЛАНГААР
А	ХӨРӨНГИЙН ЧАНАР БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ			
1	ХӨРӨНГӨ /АКТИВ/-ИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (+ илүү, -дутуу)		2,107,935,844.62	2,119,664,569.95
2	ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	5%-аас хэтрэхгүй	4.3%
3	НЭГ ГИШҮҮНД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ДМУ	30%-аас хэтрэхгүй	0.0%
4	НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ДМУ	30%-аас хэтрэхгүй	0.0%
Б	ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ			
1	НИЙТ ХӨРӨНГӨ /АКТИВ/-Д ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	60%-85%	76.9%
2	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ДМУ	10%-аас хэтрэхгүй	2.2%
3	ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	20%-80%	61.8%
4	БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ДМУ	20%-аас хэтрэхгүй	13.1%
5	НЭГ ГИШҮҮНИЙ ОРУУЛЖ БОЛОХ ХУВЬ ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	10%-аас хэтрэхгүй	0.0%
6	ХОРШООЛОГЧДЫН ӨМЧИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	5%-аас доошгүй	9.1%
7	НӨӨЦИЙН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ	ДМУ	920,540,295.55	2,733,768,277.22
8	ХАДГАЛАМЖ ХАМГААЛАЛТЫН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ	ДМУ	460,270,147.77	669,650,266.28
9	ТОГТВОРЖИЛТЫН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ	ДМУ	460,270,147.77	675,430,946.74
В	ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭ			

10	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ДМУ	15%-аас хэтрэхгүй	1.8%
Г	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР			
11	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	5%-аас доошгүй	Тооцох боломжгүй.
Д	ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ (ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ)			
12	ХӨРӨНГӨ /АКТИВ/-ИЙН ӨГӨӨЖ			0.6%

ХЗХ-дын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр зохистой харьцааны үзүүлэлтүүдийг салбарын хэмжээгээр хангаж ажилласан байна. Харин хөрөнгийн эрсдэлийн сангийн хүрэлцээг 11,728.7 мянган төгрөгөөр илүү байгуулсан байна.

Дээрх үзүүлэлтээс харахад дараагийн улиралд салбарын хэмжээнд чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдвэл зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангахгүй байж болзошгүй байгаа тул зээлийн чанарыг сайжруулахад анхаарах хэрэгтэй байна.

Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон дагаж мөрдөх үзүүлэлтийн биелэлтийг тус бүрээр харуулбал:

А. Шалгуур үзүүлэлтийг хангасан байдал:

№	ҮЗҮҮЛЭЛТ	ХЗХ-дын тоо	ХЗХ-дын тоонд эзлэх хувь
1	Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан	42	15.5%
2	1 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	51	18.8%
3	2 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	66	24.4%
4	3 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	49	18.1%
5	4 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	56	20.7%
6	5 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	6	2.2%
7	6 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	1	0.4%
	Нийт дүн	271	100%

Нийт 271 ХЗХ-дын 15.5 хувь буюу 42 ХЗХ нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Тайлант улиралд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтийг 164 ХЗХ-нд /нийслэлийн хөтөлбөрт хамрагдсан 107 ХЗХ-оог хасч/ тооцож үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

№	ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	Нийт 164 ХЗХ-дын хувьд	
			Хангасан	Хангаагүй
1	ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	5%-аас бага	130	34
2	НИЙТ ХӨРӨНГӨД ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	60%-85%	99	65
3	ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-80%	112	52
4	НЭГ ГИШҮҮНИЙ ХУВЬ ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас бага	151	13
5	ХОРШООЛОГЧДЫН ӨМЧИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	5%-аас их	107	57
6	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	5%-аас их	87	77

Хорооны 2015 оны 361 дүгээр тогтоолоор "Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр"-ийн хүрээнд байгуулагдаж Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын үйл ажиллагаанд мөрдөх зохистой харьцааны болон дагаж мөрдөх үзүүлэлтүүдийг баталсан. Дээрх журмын дагуу Нийслэлийн хөтөлбөрийн хүрээнд

байгуулагдсан нэр бүхий 107 ХЗХ-ны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тооцож үзэхэд дараах байдалтай байна.

№	ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	Нийт 107 ХЗХ-дын хувьд	
			Хангасан	Хангаагүй
1	ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	5%-аас бага	97	10
2	НИЙТ ХӨРӨНГӨД ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	60%-95%	62	45
3	ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	5%-80%	30	77
4	НЭГ ГИШҮҮНИЙ ХУВЬ ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас бага	105	2
5	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ НИЙТ ХӨРӨНГИЙН ХАРЬЦАА	5%-аас их	29	78
6	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	5%-аас их	27	80

Б. Дагаж мөрдөх үзүүлэлтийг хангасан байдал:

№	ҮЗҮҮЛЭЛТ	ХЗХ-дын тоо	ХЗХ-дын тоонд эзлэх хувь
1	Дагаж мөрдөх үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан	178	65.7%
2	1 дагаж мөрдөх үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	37	13.7%
3	2 дагаж мөрдөх үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	17	6.3%
4	3 дагаж мөрдөх үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	33	12.2%
5	4 дагаж мөрдөх үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	5	1.8%
6	5 дагаж мөрдөх үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	1	0.4%
7	6 дагаж мөрдөх үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	-	-
Нийт дүн		271	100%

Нийт 271 ХЗХ-дын 65.7 хувь буюу 178 ХЗХ нь дагаж мөрдөх үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Тайлант улиралд дагаж мөрдөх үзүүлэлтүүдийн биелэлтийг 164 ХЗХ-нд /Нийслэлийн хөтөлбөрт хамрагдсан 107 ХЗХ хасч/ тооцож үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

№	ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ДАГАЖ МӨРДӨХ ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	Нийт 164 ХЗХ-дын хувьд	
			Хангасан	Хангаагүй
1	НЭГ ГИШҮҮНД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	30%-аас бага	149	15
2	НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	30%-аас бага	160	4
3	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас бага	149	15
4	БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-аас бага	151	13
5	НӨӨЦИЙН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ	Хоршоологчдын өмчийн 10%-аас их	157	7
6	ХАДГАЛАМЖ, ХАМГААЛАЛТЫН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ	Хоршоологчдын өмчийн 5%-аас их	140	24
7	ТОГТВОРЖИЛТЫН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ		141	23
8	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	15%-аас бага	156	8

"Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр"-ийн хүрээнд байгуулагдаж Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа нэр бүхий 107 ХЗХ-ны дагаж мөрдөх үзүүлэлтүүдийг тооцож үзэхэд дараах байдалтай байна.

№	ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ДАГАЖ МӨРДӨХ ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	Нийт 107 ХЗХ-дын хувьд
---	---	--------------	---------------------------

			Хангасан	Хангаагүй
1	НЭГ ГИШҮҮНД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ХЭМЖЭЭ	5.0 саяас хэтрэхгүй	103	4
2	НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ХЭМЖЭЭ	5.0 саяас хэтрэхгүй	107	-
3	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас бага	104	3
4	НӨӨЦИЙН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ	Хоршоологчдын өмчийн 50%-аас их	82	25
5	ХАДГАЛАМЖ, ХАМГААЛАЛТЫН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ	Хоршоологчдын өмчийн 10%-аас их	82	25
6	ТОГТВОРЖИЛТЫН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ		82	25
7	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	15%-аас бага	103	4

ДОЛОО. ДҮГНЭЛТ

Тайлант улиралд нийт 21 ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бөгөөд үүнээс Улаанбаатар хотод 11, Завхан болон Баян-Өлгий аймагт тус бүр 4, Хэнтий болон Говь-Алтай аймагт тус бүр 1 ХЗХ байгуулагдаж тусгай зөвшөөрлөө авсан байна.

Санхүүгийн тайлангийн нэгтгэлд ХЗХ-д тайланг хамруулж буй байдлыг сүүлийн 3 жилийн байдлаар авч үзвэл 2011 онд 93.8 хувь, 2012 онд 96.0 хувь, 2013 онд 97.2 хувь, 2014 онд 95.0 хувь, 2015 онд 100 хувь, 2016 оны 1 дүгээр улирлын байдлаар мөн 100 хувийн ирцтэй байна.

Тайлант улирлын санхүүгийн үзүүлэлтүүдийг авч үзвэл:

1. Нийт актив

Тайлант онд ХЗХ-дын активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15,757,733.9 мянган төгрөгөөр буюу 18.4 хувиар өсч 101,526,431.9 мянган төгрөгт хүрсэн нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 0.5 хувьтай тэнцэж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-дын хувьд гишүүдийн тоо 8,023-аар, нийт актив 13,695,151.7 мянган төгрөгөөр буюу 18.6 хувиар, орон нутгийн ХЗХ-дын хувьд гишүүдийн тоо 1,016-аар өсч, нийт актив 2,062,582.0 мянган төгрөгөөр буюу 16.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

"Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр"-ийн хүрээнд байгуулагдаж Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 107 ХЗХ-ны нийт хөрөнгийн хэмжээ 10,709,566.5 мянган төгрөгт хүрч салбарын 10.5 хувийг эзэлж байна.

Санхүүгийн зохицуулах хороо байгуулагдаж ХЗХ-оод тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа эрхлэх болсноос хойш анх удаа салбарын актив хөрөнгө 100.0 тэрбум төгрөгийг давсан нь ХЗХ-оодын үйл ажиллагаа улам өргөжиж байгааг харуулж байна.

2. Нийт зээлийн үлдэгдэл

Нийт зээлийн үлдэгдэл 80,318,082.9 мянган төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 0.7 хувьтай тэнцэж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээлийн багц 8,735,753.9 мянган төгрөгөөр буюу 12.2 хувиар, чанаргүй зээлийн хэмжээ 1,491,672.7 мянган төгрөг буюу 75.9 хувиар тус тус өссөн байна. Чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдсэнээр зээлийн эрсдэлээс хамгаалах сан 988,034.6 мянган төгрөгөөр буюу 91.2 хувиар өссөн байгааг анхаарч зээлийн чанар муудаж байгаа ХЗХ-дод хяналтыг сайжруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Мөн нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ өнгөрсөн оны мөн үед 2.5 хувь байсан бол тайлант улиралд 4.3 хувь болж өссөн байгааг анхаарах хэрэгтэй.

3. Татан төвлөрүүлсэн хадгаламж

Нийт хадгаламжийн үлдэгдэл 62,808,344.1 мянган төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 10.8 хувьтай тэнцэж байна. Хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 6,144,916.1

мянган төгрөгөөр буюу 10.8 хувиар өссөн ба нийт мөнгөн хадгаламжийн 96.4 хувь нь хугацаатай, 3.6 хувь нь хугацаагүй хадгаламж байна.

4. Хувь хөрөнгийн хэмжээ

Хувь хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 995,164.8 мянган төгрөгөөр буюу 9.8 хувиар өсч, гишүүдийн тоо 9,039-өөр нэмэгдсэн байна. Нийт хувь хөрөнгө тайлант онд 11,107,870.4 мянган төгрөг байгаа ба үүний 99.8 хувь буюу 11,082,206.5 мянган төгрөг нь идэвхтэй гишүүний хувь хөрөнгө бол 0.2 хувь буюу 25,663.9 мянган төгрөг нь идэвхгүй гишүүний хувь хөрөнгө байна.

4. Хоршоологчдын өмч

Хоршоологчдын өмчийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1,316,043.0 мянган төгрөгөөр буюу 16.3 хувиар өссөн. Салбарын хэмжээнд хувь хөрөнгө болон хоршоологчдын өмчийн хэмжээ өссөн хэдий ч нэр бүхий 118 ХЗХ хоршоологчдын өмчгүй болсон байгааг Хорооноос анхаарч ажиллах хэрэгтэй.

Мөн нэр бүхий 23 ХЗХ алдагдалтай ажиллаж, өөрийн хөрөнгөгүй болсон нь Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 56.5-д "Санхүү төлбөрийн чадвар муудсан, өөрийн хөрөнгөгүй болсон тухай бүр ХЗХ-ны үйл ажиллагаанд Хорооноос хяналт шалгалтыг хийнэ" заасан нөхцөл бүрдсэн гэж үзэж байна.

5. Нийт орлого, ашиг

ХЗХ-дын нийт орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 1,031,619.5 мянган төгрөгөөр буюу 20.4 хувиар, нийт зардлын хэмжээ 892,303.2 мянган төгрөгөөр буюу 19.6 хувиар тус тус өсч тайлант улирлын байдлаар цэвэр орлого 622,399.3 мянган төгрөг байна. Тайлант үеийн ашгийг өмнөх оны мөн үеийн байдалтай харьцуулахад 139,316.3 мянган төгрөгөөр буюу 28.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

6. Зохистой харьцааны үзүүлэлт

Нийт 271 ХЗХ-дын 15.5 хувь буюу 42 ХЗХ нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг, 65.7 хувь буюу 178 ХЗХ нь дагаж мөрдөх үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан байна.

ХЗХ-дын хөрөнгө, зээл, хадгаламж, орлого, гишүүдийн тоо зэрэг үндсэн үзүүлэлтүүд өссөн байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулж үр дүнг нэгтгэн дүгнэвэл нийт активын хэмжээ 18.4 хувиар, нийт зээлийн хэмжээ 12.2 хувиар өсч, нийт орлого 20.4 хувиар нэмэгдсэн байна. Энэхүү хөрөнгийн өсөлтөд төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн хэмжээ 10 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн бөгөөд үйл ажиллагаа өргөжсөнтэй холбогдож гарсан зардал болон эх үүсвэрийн зардлаас шалтгаалж нийт зардал 19.6 хувиар өссөн байна.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР